



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

“Залууст ээлтэй дүүрэг” залуучуудын
өдөрлөг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Залуу үеийнхний дуу хоолойг сонсох, залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлого шийдвэрийг сурталчилан таниулах, Төрийн бодлого, үйл ажиллагаа, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Залууст ээлтэй дүүрэг” сэдэвт залуучуудын өдөрлөг зохион байгуулахыг Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс /Т.Уламбаяр/-т даалгасугай.
2. Арга хэмжээний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
3. Арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100095



“Залууст ээлтэй дүүрэг” залуучуудын
өдөрлөгийн удирдамж

Зорилго: Залуу үеийнхний дуу хоолойг сонсох, залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлого шийдвэрийг сурталчилан таниулах, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, тэдний санал санаачлагыг дэмжин, Төрийн бодлого, үйл ажиллагаанд тусгуулах, залуучуудын клубын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд оршино.

Хугацаа: 2015 оны 05 сарын 17-ны өдрийн 10⁰⁰ цагт

Хаана: Энхийн төлөө цогцолборт

Хамрах хүрээ: Чингэлтэй дүүргийн 1-19 дүгээр хорооны нийт 130 залуучууд оролцоно.

Зохион байгуулах хэлбэр: Сургалт, лекц, ярилцлага, чөлөөт арга хэмжээ

Зохион байгуулалт:

10⁰⁰-10¹⁰ Нээлт:

/Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга
Д.Бат-Эрдэнэ/

10¹⁰-11³⁰ “Монголын ирээдүй бид” сэдэвт лекц

/“Монгол залуу хүн” ТББ-ын тэргүүн А.Отгонбаатар/

11²⁰-11⁴⁰ Цайны завсарлага

11⁴⁰-13⁰⁰ “Дүүргийн хөгжилд залуучуудын оролцоо” сэдэвт сургалт

/Монголын Мэтгэлцээний Нэгдсэн Ассоциацийн сургагч багш,
Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Төлөөлөгч Д.Ядамжав /

13⁰⁰-14⁰⁰ Өдрийн хоол

14⁰⁰-14³⁰ Залуучуудад тулгамдаж буй асуудлууд, түүнийг шийдвэрлэх
арга зам, чөлөөт ярилцлага

14³⁰-17⁵⁰ Чөлөөт арга хэмжээ /спортын уралдаан тэмцээн/

17⁵⁰-18⁰⁰ Хаалт

/Иргэний оролцооны хэлтсийн дарга Т.Уламбаяр/

Үр дүн: Залуу үеийнхний дуу хоолойг Төрийн бодлого, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх, залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлого шийдвэрийг сурталчилан таниулж, Төрийн бодлого, үйл ажиллагаа, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоо нэмэгдэнэ.



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Уулзалт, хэлэлцүүлэг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэл, дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтсүүдийн ээлжит уулзалт, хэлэлцүүлгийг Чингэлтэй дүүрэгт зохион байгуулахыг Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс /Г.Уламбаяр/-т даалгасугай.
2. Уулзалт, хэлэлцүүлгийн удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.
3. Шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100093

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар сарын
11-ний өдрийн 41 дүгээр тогтоолын хавсралт



Уулзалт, хэлэлцүүлгийн удирдамж

Зорилго: Нийслэл, дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтсийн хамтын ажиллагааг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, Төрийн бодлого, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах шинэлэг санал, санаачлагыг хэрэгжүүлэхэд оршино.

Хугацаа: 2015 оны 05 сарын 25-ны өдрийн 10⁰⁰ цагт

Хаана: "Бишрэлт" рестораны хурлын танхимд

Оролцогчид: Нийслэл, дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтсийн албан хаагчид, Иргэний танхимын ажилтнууд

Хэлэлцүүлгийн сэдэв: Иргэний оролцооны тухай хуулийн төсөл

Уулзалтын чиглэл: Уулзалт, хэлэлцүүлгийн материалыг Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс дараах чиглэлээр бэлтгэнэ.

- Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын товч танилцуулга
- Иргэдийн оролцоог хангах чиглэлээр Хурал, Тэргүүлэгчдээс дэвшүүлсэн бодлого зорилт, түүний явц, хэрэгжилт, үр дүн
- "Иргэний оролцоог хангах тухай хууль"-ийн хэлэлцүүлэг

Зохион байгуулалт: Уулзалт хэлэлцүүлэгт Нийслэл, дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс, Иргэний танхимын ажилтнууд оролцох бөгөөд оролцогчдын нэрсийг 2015 оны 05 сарын 20-ны дотор бүртгэнэ. Оролцогчдыг шаардлагатай гарын авлага, материалаар хангана.

Үр дүн: Нийслэл, дүүргүүдийн Иргэний оролцооны хэлтсийн хамтын ажиллагаа дээшилж, харилцан туршлага солилцох замаар Төрийн бодлого, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах шинэлэг санал, санаачлагыг хэрэгжүүлнэ.



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Үзүүлэх сургалт зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Чингэлтэй дүүргийн 19 хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарын үзүүлэх сургалтыг 7 дугаар хороонд зохион байгуулахыг Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтэс /Т.Уламбаяр/-т даалгасугай.
2. Сургалтын удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.
3. Шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100096

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар сарын
11-ний өдрийн 42 дугаар тогтоолын хавсралт



Иргэдийн нийтийн хурлын дарга нарын
үзүүлэх сургалтын удирдамж

Зорилго: Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааны талаар харилцан туршлага солилцож, хамтын ажиллагааг өргөжүүлэх, нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлэхэд оршино.

Хугацаа: 2015 оны 05 сарын 22-ны өдрийн 14⁰⁰ цагт

Хаана: Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны Иргэний танхим

Хамрах хүрээ: Чингэлтэй дүүргийн 1-19 дүгээр хорооны Иргэдийн Нийтийн Хурлын дарга

Зохион байгуулалт:

14⁰⁰-14¹⁰ Нээлт:

/Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны Иргэдийн Нийтийн Хурлын дарга Д.Баянбат/

14¹⁰-14³⁰ Урлагийн тоглолт

14³⁰-14⁵⁰ Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааны талаар товч мэдээлэл хийх

/Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны Иргэдийн Нийтийн Хурлын дарга Д.Баянбат/

14⁵⁰-15⁰⁰ Хорооны Иргэдийн Нийтийн Хурал, Засаг даргын хамтын ажиллагааны талаар

/Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны Засаг дарга Ц.Дуламжав/

15⁰⁰-15¹⁰ Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны Иргэний танхимын үйл ажиллагааны талаар товч мэдээлэл хийх

/Иргэний танхимын ажилтан О.Бат-Эрдэнэ/

15¹⁰-15⁵⁰ Санал солилцох

15⁵⁰-16⁰⁰ Хаалт



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 165 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа хавсралтад нэр дурдсан иргэдийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал "Чандмань одон", мөнгөн шагналаар шагнасугай.

2. Шагналд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.


ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

11501009217

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 05 дугаар сарын
11-ний өдрийн 43 дугаар тогтоолын хавсралт



“Чандмань одон”-гоор шагнагдах хүмүүсийн нэрс

Д/д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
1	С.Нямзаяа	Чингэлтэй дүүргийн “Цэцэнжаргалхайрхан” Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч	Д386100500
2	У.Уранчимэг	Чингэлтэй дүүргийн “Мөнх үйлстэн” Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч	ЧР58040967
3	Ж.Энэбиш	Чингэлтэй дүүргийн “Үйлс нэгтэн” Өрхийн эрүүл мэндийн төвийн Сэргээн засах, бариа заслын сувилагч	У356041209
4	Г.Базаррагчаа	Чингэлтэй дүүргийн “Чин хүслэн” Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч	ИЦ67021206
5	Л.Хишигжаргал	Чингэлтэй дүүргийн “Нандин хүсэл” Өрхийн эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч	ЧО65040922
6	Д.Пүрэвээ	Чингэлтэй дүүргийн “Шэжиддүг” Өрхийн эрүүл мэндийн төвийн Нөхөн үржихүйн эмэгтэйчүүдийн сувилагч	МЮ71052080
7	Д.Цэцэгсүрэн	Чингэлтэй дүүргийн, 13-р хорооны “Мэнд-Арвижих” Өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч	ХЕ77032804
8	П.Рагчаа	Чингэлтэй дүүргийн “Ундрах ирээдүй” Өрхийн эрүүл мэндийн төвийн	УС68021903
9	П.Отгонжаргал	Чингэлтэй дүүргийн “Энэрэнгүй сэтгэл” Өрхийн эрүүл мэндийн төвийн физик эмчилгээний сувилагч	ХЖ55090503
10	Глинда Лий	Их хөлгөний Уламжлалыг хадгалах төвийн Номын хөтөлбөрийн багш	PE0374882
11	Ц.Туул	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны ахмад настан	ХН55071726
12	Л.Цэнд	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны ахмад настан	ЧГ53102577
13	П.Гэрэлцэцэг	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны иргэн	АЮ63112364
14	О.Мөнхбаатар	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны иргэн	ЖЮ89082874
15	Б.Боргил	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны ахмад настан	Ш343072060